



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 635

Улаанбаатар хот

**Хөрөнгө, өр төлбөр бүртгэх зөвшөөрөл
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дах заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Улсын төсөв, Хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн Дорноговь аймгийн Сайншанд сумын 6 дугаар баг (хороо)-ны нутаг дэвсгэрт баригдсан бага төвөгшилтэй ангиллын 40 айлын орон сууцны хүчин чадал бүхий “Монгол Газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн ажилчдын орон сууцны хотхоны 40-4 барилгын ажлын хүрээнд бий болсон 2 нэрийн, нийт 4,741,252,722.00 (дөрвөн тэрбум долоон зуун дөчин нэгэн сая хоёр зуун тавин хоёр мянга долоон зуун хорин хоёр) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгө болон холбогдох өр төлбөрийг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бямбадагва, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх, хөрөнгө, өр төлбөрийн тооцоо нийлж баталгаажуулах ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгө өр төлбөрийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

31-р хуралдаан
134033856

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 11 дугаар сарын 17 ны өдрийн
63... дугаар тогтоолын хавсралт

**"МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

№	Хөрөнгийн нэр	Төсөвт өртөг	Гүйцэтгэлийн дүн	Зээлийн хүү	Нийт дүн
1	40 айлын орон сууцны барилга	3,216,750,248.00	2,891,193,001.00	555,107,724.00	3,446,300,725.00
2	Гадна инженерийн шугам сүлжээ	5,502,981,221.00	1,116,246,066.00	178,705,931.00	1,294,951,997.00
		8,719,731,469.00	4,007,439,067.00	733,813,655.00	4,741,252,722.00
	Нийт дүн	(найман тэрбум долоон зуун арван есөн сая долоон зуун гучин нэгэн мянга дөрвөн зуун жаран есөн)	(дөрвөн тэрбум долоон сая дөрвөн зуун гучин есөн мянга жаран долоон)	(долоон зуун гучин гурван сая найман зуун арван гурван мянга зургаан зуун тавин таван)	(дөрвөн тэрбум долоон зуун дөчин нэгэн сая хоёр зуун тавин хоёр мянга долоон зуун хорин хоёр)